



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/321

Булган сум

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Геовиб замын суурийн материал (Орхон сум)”-ыг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

С.Сүхбаатар (Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Авто замын улсын байцаагч)

Б.Будцэцэг (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

М.Алтанцэцэг (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Дэлгэр (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

